



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2023 оны 06 сарын 22 өдөр

Дугаар 321

Улаанбаатар хот

┌ Үндсэн хөрөнгийн үнэлгээг нэмэгдүүлэн ┐
бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 1.2, 1.3, 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Говь-Алтай аймгийн Онцгой байдлын газрын биет бус хөрөнгөд бүртгэлтэй 38,572.6 м.кв бүхий газар (эзэмших эрх)-ын 39,244 м.кв болгон үнэлгээг 671.4 м.кв-ын 3,366,480.00 (гурван сая гурван зуун жаран зургаан мянга дөрвөн зуун наян) төгрөгөөр нэмэгдүүлэн бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Говь-Алтай аймгийн Онцгой байдлын газрын дарга, дэд хурандаа Ц.Лувсанжамцад дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийн үнэлгээг нэмэгдүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, арга хэмжээний биелэлтийг 2023 оны 3 дугаар улиралд багтаан тайлагнах.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ